



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 03 өдөр

Дугаар 66.

Пионер толгой

“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд
мод тарих ажлыг зохион байгуулах
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль хамгаалах тухай хуулийн 17.2.1, Ойн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.1, 31 дүгээр зүйлийн 31.2, Хөрс хамгаалах, цэлжилтээс сэргийлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.4 дахь заалт, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 63, 2021 оны 58 дугаар зарлигийг тус тус үндэслэн **ЗАХИРАМЖЛАХ** нь:

1. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигийн дагуу “Тэрбум мод” тарих үндэсний хөдөлгөөний хүрээнд иргэн бүр мод тарьж, ургуулах ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлыг 2022 оны 05 дугаар сарын 04-ний өдрөөс 2022 оны 10 дугаар сарын 10-ны өдрийг хүртэл хугацаанд сумын хэмжээнд зохион байгуулсугай.

2. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг сумын хэмжээнд зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, ажлын төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд мод тарихын ач холбогдлыг иргэдэд сурталчилан таниулж, мод тарих ажилд иргэн, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийг өргөнөөр татан оролцуулж үр дүнтэй зохион байгуулж биелэлтийг тайлagnаж ажиллахыг ажлыг хэсгийн ахлагч болон гишүүдэд үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга (Р.Гантулга)-д даалгасугай.

ДАРГА  Б.ГАНТУЛГА

64^101229